

**Сургалтын албанаас оюутнуудын нийтлэг асуудаг асуулт, хариулт**

№	Асуулт	Хариулт
1	Шалгалт өгөөд дүнгээ гаргуулсан байхад СиСи-д дүн яагаад орохгүй байна вэ?	<p>Бакалаврын сургалтын журмын 16.11.6-д зааснаар “Шалгагч багш шалгалт авснаас хойш ажлын 5 хоногийн дотор мэдээллийн системд оруулан, салбар сургалтын албанаас шалгагдвал зохих оюутны нэрс, өөрийн тавьсан дүн бүхий хуудсыг хэвлүүлэн авч, хянан, гарын үсгээр баталгаажуулан, хүлээлгэн өгнө. Шалгалтын хуудсанд гараар засвар хийхийг хориглоно”. Хэрвээ багш уг хугацаанд дүнгээ системд оруулаагүй бол дүн харагдахгүй. Өөр нэг нийтлэг шалтгаан бол оюутан төлбөрөө төлж хичээл баталгаажуулаагүй бол дүн оруулах боломжгүй.</p> <p>Багш нь хугацаандаа дүнгээ оруулаагүйгээс дүн нь СиСи-д ороогүй бол өргөдөл бичиж тэнхмийн эрхлэгчид хандана уу.</p>
2	R тэмдэглэгээг ямар тохиолдолд тавиулах вэ? Нийт хэдэн удаа тавиулах боломжтой бэ?	<p>Бакалаврын сургалтын журмын 16.11.5-д зааснаар “Тухайн хичээлийг амжилттай судалсан ч тодорхой шаардлагаар дахин судлах хүсэлт гаргасан бол оюутны өмнөх үнэлгээний үсгээр илтгэсэн дүнг “R” болгож, дахин судлах боломжоор хангана”. Ихэнхдээ тухайн хичээлийг дахин судалж дүнгээ ахиулах зорилготой оюутнууд байдаг учир “R” тэмдэглэгээг нийт суралцах хугацаандаа 3 хичээл дээр тавиулж болно.</p>
3	CR тэмдэглэгээг ямар тохиолдолд тавиулах вэ?	<p>Өөр сургуулиас шилжиж ирсэн болон оюутан солилцоогоор суралцаад ирсэн суралцагчдын багц цагийг шилжүүлэн тооцох үед CR тэмдэглэгээг хийх ба дипломын хавсралтан дээр энэ хэвээрээ бичигдэнэ. Учир нь өөр сургуульд хичээл үзээд авсан дүнг бид тооцон дүгнэж тавих нь зохимжгүй юм /Оноо болон үсгэн дүн бичигдэхгүй/. CR тэмдэглэгээ нь дүнгийн голчид нөлөөлөхгүй.</p>
4	Хичээл цуцлалтын хугацаа дууссан байхад хичээл цуцалж болох уу ?	<p>Бакалаврын сургалтын журмын 13.12-д зааснаар “Улирлын хичээл эхэлснээс хойш, сургалтын төлөвлөгөөн дэх тухайн хичээлийн цагийн 30 хувь өнгөрөөгүй байхад баталгаажуулсан хичээлээ цуцлах тохиолдолд хичээлийн багц цагийн төлбөрийн 70 хувийг дараагийн улиралд бүртгүүлэх хичээлийн багц цагийн төлбөрт шилжүүлнэ. Хичээлийн цагийн 30-аас дээш хувь</p>

		<p>өнгөрсөн бол багц цагийн төлбөрийг буцааж олгохгүй”. Аль ч тохиолдолд тухайн улирлын суурь үйлчилгээний төлбөрийг буцааж олгохгүй.</p>
5	<p>Хичээл баталгаажуулах хугацаа дууссаны дараа хичээл баталгаажуулж болох уу?</p>	<p>Болохгүй. Гэхдээ Бакалаврын сургалтын журмын 13.15-д зааснаар Хүндэтгэн үзэх шалтгаанаар заасан хугацаанд хичээлдээ бүртгүүлж амжаагүй суралцагч тухайн улирлын эхний 14 хоногт багтан бүртгүүлэх боломжтой хичээлд бүртгүүлнэ. Бусад тохиолдолд бүртгэлийн хураамж төлж, улирлын эхний 14 хоногоос хэтрэхгүй боломжит хичээлд бүртгүүлнэ. Бүртгэлийн хураамж нь тухайн хичээлийн 1 багц цагийн төлбөртэй дүйцэхүйц байна.</p>
6	<p>Хөтөлбөр тандалт гэж юу вэ, хэрхэн хийх вэ?</p>	<p>Оюутан мэргэжлийн хөтөлбөр сонгох тандалтыг хичээлийн жилд Сиси мэдээллийн системээр 2-оос доошгүй удаа өгөх бөгөөд цаашид суралцахаар зорьж буй 3 /ОУХНУС хувьд 2/ мэргэжилд саналаа өгөх боломжтой.</p> <p>Эхний удаагийн мэргэжлийн хөтөлбөр сонгох тандалтыг оюутан МУИС-д элсэх эрхээ баталгаажуулах бүртгэлийн үед, 2 дахь тандалтыг 12 дугаар сард /БС, Орхон, Завхан сургуулийн хувьд 1-р тандалтын 1-р сард, 2 дахь тандалтыг 6 сард/ багтаан явуулна. Жишээлбэл ХШУИС-ийн 21 хөтөлбөрөөс 1, 2, 3-р сонголт гэсэн 3 хувилбарт санал өгөх ёстой. Хөтөлбөр тандалт хийж байгаа шалтгаан нь аль хөтөлбөрт хэдэн оюутан авах хяналтын тоо бодох нэг параметр болгон ашиглах тоог гарган авах юм. Мэргэжлийн хөтөлбөр сонгох тандалтын 1-р сонголт гэдэг нь оюутны элсэхийг хүсч байгаа хөтөлбөр 1, 2, 3-д өгсөн саналын онооны жагсаалт дахь байр нь 1-рт өгсөн хөтөлбөрөө сонгох боломжгүй бол 2 дахь, 2-рт өгсөн хөтөлбөртөө орж чадахааргүй бол 3 дахь хөтөлбөр нь аль байх вэ гэдэгт саналаа өгөх юм.</p> <p>Хөтөлбөр тандалт хийж чадахгүй байгаа оюутанууд сиси рүү орж буй хөтөчөө сольж үзэх хэрэгтэй. Chrome эсвэл firefox-оор орж хөтөлбөр тандалт өгч болно. Internet explorer болохгүй байгаа. Тандалт өгөх хэсэг алга болсон бол сиси-ээс гараад дахин оруулаарай. Нэг оюутан нийт 3 хөтөлбөрт саналаа өгөх боломжтой.</p>
7	<p>W тэмдэглэгээний талаар, R тэмдэглэгээнээс юугаараа ялгаатай</p>	<p>Бакалаврын сургалтын журмын 16.11.5-д зааснаар “Тухайн хичээлийг оюутан цаашид</p>

	вэ?	судлах боломжгүй эсвэл хангалтгүй судалсан бол улирлын шалгалтаас өмнө өөрийн саналаар уг тэмдэглэгээг хийлгэнэ. Дахин судлах хичээлийг шинээр үзэх хичээлийн адил бүртгэж тооцно”. W тэмдэглэгээ нь дүнгийн голч оноонд нөлөөлөхгүй бөгөөд харин тухайн улиралд судлаж буй нийт багц цагаас W тэмдэглэгээ тавиулсан хичээлийн багц цаг хасагдана. W тэмдэглэгээ тавиулсан хичээлийг дараагийн улиралд дахин судалсан ч болно эсвэл тухайн хичээл байдаг бүлгээс өөр хичээл сонгон судлах боломжтой. Гэхдээ W-г тавиулсан хичээл нь заавал судлах хичээл байвал өөр хичээл сонгож болохгүй. W тэмдэглэгээ нь оюутны хүсэлт дээр тулгуурлан тавигддаг үнэлгээ учраас суралцах хугацаандаа хэдэн ч удаа тавиулах боломжтой. Харин R тэмдэглэгээ нь оюутан тухайн хичээлийг амжилттай судалсан ч тодорхой шаардлагаар дахин судлах, дүнгээ ахиулах хүсэлтэй бол тавиулах боломжтой тэмдэглэгээ юм.
8	Сургалтын төлбөрөөс 10%-ийг буцаан олгодог гэсэн. Ямар нөхцөлд буцаан олгодог юм бэ?	Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 6-7-р заалтаар гадаад, дотоод сургуулийн сургалтын төлбөрийн хөнгөлөлтөнд хамрагдах тохиолдолд сургалтын төлбөрийн 10%-ийг Татварийн ерөнхий газраас буцаан олгодог. Татварын буцаан олголтыг авахын тулд жил бүрийн 2 сарын 15-наас өмнө татварын албанд бичиг баримтаа бүрдүүлэн өгөх шаардлагатай.
9	Үндэсний тэтгэлэг 70200-г хэрхэн хамрагдах бэ?	Монгол улсын засгийн газрын 2014 оны 03-р сарын 07-ны өдрийн 71 дугаар тогтоол, Монгол улсын засгийн газрын 2015 оны 01-р сарын 26-ны өдрийн 26 дугаар тогтоолын дагуу бакалаврын суралцагч 1 улиралд доод тал нь 12 багц цагийн хичээл сонгосон ба дүнгийн голч оноо нь 3.0-с дээш тохиолдолд, магистр, докторын суралцагч 1 улиралд доод тал нь 10 багц цагийн хичээл сонгосон ба дүнгийн голч оноо нь 3.2-с доошгүй, 3.5-с доошгүй тохиолдолд үндэсний тэтгэлэгт хамрагдана. Аль нэг түвшинд суралцаж байх хугацаандаа үндэсний тэтгэлэгт хамрагдчихаад өөр сургуульд шилжиж очсон бол тухайн жилдээ тэтгэлэг авахгүй ба нэг оюутан суралцах хугацаандаа нийт 4 жил тэтгэлэг авах боломжтой юм.
10	Урамшуулалт тэтгэлэгт гэж юу	Үндэсний тэтгэлэгийн 50% болон 75%-ийг

	вэ? Ямар нөхцөлд хамрагдах вэ?	амжилттай суралцаж байгаа суралцагчдад урамшуулал болгон олгодог тэтгэлэг юм. Ингэхдээ 3.6-с дээш голч оноотой суралцсан бол 50%, 3.8-с дээш голч оноотой суралцсан бол 75%-ийг үндэсний тэтгэлэгийн дээрээ нэмж урамшуулал болгон авна гэсэн үг юм.
11	Англи хэлийг заавал түвшин ахиулж судлах юм уу эсвэл 6 кредит үзээд хаах юм уу?	Ерөнхий суурийн гадаад хэлний багц цаг 6. Англи хэлний хичээлийг түвшин тогтоосны үндсэн дээр судлах бөгөөд мэргэжлийн хөтөлбөр сонгоход гадаад хэлний багц цагийг бүрэн судалсан байх шаардлагатай. 2014 оны элсэгчдээс эхлээд төгсөхдөө англи хэлний upper intermediate түвшинд хүрсэн байх шаардлагатай тул түвшин ахиулж судлах нь зохимжтой.
12	Хөтөлбөр хэрхэн сонгох вэ?	ШУС, ХШУИС, ОУХНУС, Орхон сургуулийн хэлний хөтөлбөрийн хувьд 2 улиралд МУИС-ийн ерөнхий суурь хичээлээс 24-оос доошгүй багц цагийн хичээл харин БС, Завхан сургууль, Орхон сургуулийн хэлнээс бусад хөтөлбөрийн хувьд 3 улиралд буюу 1.5 жилд 36-аас доошгүй багц цагийн хичээл амжилттай судалсан оюутан мэргэжлийн хөтөлбөрөө сонгоно. Хөтөлбөр сонгохдоо оюутны сурлагын голч дүн болон цуглуулсан багц цаг, ЭЕШалгалтын оноог МУИС-ийн мэдээллийн системээр тэдгээрийн жинлэсэн нийлбэрийн дунджаар эрэмбэлэн жагсааж, байр эзлүүлнэ. Жагсаалтын эхнээс эхлэн хөтөлбөрөө сонгох ба хяналтын тоонд багтсан ч хөтөлбөр сонгох өдрийн зарласан цагт оюутан өөрийн биеэр ирээгүй тохиолдолд онооны дарааллаар дараагийн оюутанд сонголт хийх эрхийг шилжүүлнэ. Хөтөлбөр сонголтонд ирээгүй болон жагсаалтын доогуур орсон оюутнууд үлдсэн хөтөлбөрт шууд харьяалагдана. 2014-2015 оны хичээлийн жилд элссэн бакалаврын түвшний оюутны мэргэжлийн хөтөлбөр сонгох журмаар зохицуулагдана.
13	Ерөнхий суурь хичээлүүдийн багцаас илүү багц цаг судалсан бол яах вэ, W үнэлгээ тавиулж болох уу?	Ерөнхий суурь хичээлийн нэг бүлгээс судлах ёстой багц цагаасаа илүү багц цаг судласан тохиолдолд тухайн илүү багц цагийг дараа нь чөлөөт сонголтын 15 багц цагаас хасуулан тооцуулах боломжтой. Өөр бүлгээс илүү судласан илүү багц цагийг бусад бүлэгт хамруулан тооцох боломжгүй ба илүү судалсан багц цагт W үнэлгээ тавиулах шаардлага байхгүй.

		W тэмдэглэгээг зөвхөн судалж дуусаагүй буюу дүгнэгдээгүй хичээлд тавих тул боломжгүй.
14	Сургууль дотроо өөр хөтөлбөр рүү шилжихэд ямар шаардлага хангасан байх ёстой вэ?	Тухайн шилжин суралцахыг хүссэн суралцагч нь 2-оос доошгүй улирал 2.8-аас багагүй голч дүнтэй суралцсан, улиралд дунджаар 12-оос багагүй багц цаг цуглуулсан байх ёстой. Өөр их дээд сургуулиас шилжин ирэх хүсэлтэй бол голч оноо нь 3.2-с дээш байна. Мэргэжлийн хөтөлбөрийн онцлогоос хамааран нэмэлт шалгалт авах, ярилцлага хийх, шилжин суралцах түвшинг тогтоох зэргийг бүрэлдэхүүн сургуулийн дотоод журмаар зохицуулах ба шилжилтийн журам болон дэлгэрэнгүй мэдээллийг <a href="http://www.num.edu.mn">www.num.edu.mn</a> , <a href="http://www.shiljilt.edu.mn">www.shiljilt.edu.mn</a> хаягаар авна уу.
15	Улиралд 21-ээс илүү кредит үзэж болох уу, ер нь 1-р түвшинд хэдэн багц цаг судлах боломжтой вэ?	Бакалаврын сургалтын журмын 13.16-д зааснаар “Оюутан хичээлийн 16 долоо хоногтой улиралд дунджаар 15 багц цагийн хичээл судлах нь зохимжтой бөгөөд судлавал зохих багц цагийн дээд хэмжээ 21 байна”.
16	Ерөнхий суурь хичээлийн 8 багцаас тус бүр хэдэн багц цаг судлах ёстой вэ?	<p><b>Бизнесийн сургууль, ХШУИС, ОУХНУС-ийн оюутнууд</b></p> <p>1.Байгалийн ухаан 3 багц цаг</p> <p>2.Хүмүүнлэгийн ухаан 3-6 багц цаг</p> <p>3.Нийгмийн ухаан 3-6 цаг цаг</p> <p>4. Иргэний болосврол 3 багц цаг</p> <p>5.Судалгаа шинжилгээний аргй зүй 3 багц цаг</p> <p>6.Яриа бичгийн ур чадвар 3 багц цаг</p> <p>7.Англи хэл бусад хэл 6 багц цаг</p> <p>8. Биеийн тамир эрүүл ахуй 3 багц цаг</p> <p><b>Шинжлэх ухааны сургуулийн оюутнууд</b></p> <p>1.Байгалийн ухаан 6 багц цаг</p> <p>2.Хүмүүнлэгийн ухаан 6 багц цаг</p> <p>3.Нийгмийн ухаан 6 цаг цаг</p> <p>4. Иргэний болосврол 3 багц цаг</p> <p>5.Судалгаа шинжилгээний аргй зүй 3 багц цаг</p> <p>6.Яриа бичгийн ур чадвар 3 багц цаг</p> <p>7.Англи хэл бусад хэл 6 багц цаг</p> <p>8. Биеийн тамир эрүүл ахуй 3 багц цаг</p>
17	Хос болон хавсрага мэргэжлээр суралцахад тавигдах шаардлага нь ямар байх ёстой вэ?	Бакалаврын сургалтын журмын 15.15-д зааснаар оюутан эзэмшихээр суралцаж буй үндсэн мэргэжлийнхээ сургалтын төлөвлөгөөн дэхь ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлийг бүрэн судалж, мэргэшүүлэх хичээлийн багц цагийн 1/3-ийг амжилттай цуглуулсан, суралцсан хугацааны голч дүн 3.2-оос дээш байх нийтлэг шаардлагыг хангасан байна. Хос

		<p>мэргэжлээр суралцах эрхийг бүрэлдэхүүн сургуулиудын зөвшөөрлийг үндэслэн МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна.</p> <p>Мөн журмын 15.13-д зааснаар Оюутан суралцаж байгаа үндсэн чиглэлийнхээ мэргэшүүлэх хичээлээс цуглуулах багц цагийг 18 болгож багасган, тухайн чиглэлд хоёр дахь мэргэшлийг эзэмших, эсвэл суралцаж байгаа чиглэлээсээ өөр чиглэлд хавсрага хэлбэрээр суралцаж болно. Үндсэн чиглэлийнхээ мэргэшүүлэх хичээлээс цуглуулах багц цагийн 60-аас доошгүй хувийг амжилттай цуглуулсан, хавсрага хөтөлбөрийг хариуцсан мэргэжлийн тэнхим/профессорын багаас тавьсан тусгай шаардлагуудыг хангасан оюутан тухайн хавсрага хөтөлбөр харьяалагдах мэргэжлийн тэнхим/профессорын баг, салбар сургалтын албанд хандан, хүсэлтээ баталгаажуулна.</p>
18	Дипломын судалгааны ажил бичихэд тавигдах шаардлага юу вэ?	Бакалаврын сургалтын журмын 15.12-д зааснаар Бакалаврын судалгааны ажил нь 3 багц цаг байх ба үндсэн мэргэшлийн сургалтын төлөвлөгөөний мэргэшүүлэх бүлгийн сонгон судлах хэсэгт тусгана. Бакалаврын судалгааны ажлын шаардлагыг тухайн хөтөлбөрийн мэргэжлийн тэнхим/профессорын баг гаргана.
19	Одоо судалж байгаа хичээл дээрээ унавал заавал тэр хичээлээ дахин үзэх үү?	Заавал үзэх ерөнхий суурь хичээл эсвэл мэргэжлийн суурь хичээл дээр унавал тэр хичээлээ дахин судлах шаардагатай. Харин сонгон судлах хичээл бол дахин судлахгүй байж болно.
20	Смарт карт дахин хаана захиалах вэ?	Оюутны смарт картны захиалгыг Монголын оюутны холбоо хариуцан захиалдаг тул Бүрэлдэхүүн сургуулийнхаа оюутны зөвлөлөөр дамжуулан Смарт картны захиалгаа өгнө.
21	Үсгэн үнэлгээнүүдийг тавиулахад голч оноонд нөлөөлөх үү?	Бакалаврын сургалтын журмын 16.11.5-д зааснаар Оюутныг үнэлэхдээ тоо болон үсгээр илтгэсэн дүнг хэрэглэхээс гадна I, E, NC, CR, R, W, WF, NA, NR, S, U гэсэн нэмэлт тэмдэглэгээг хэрэглэнэ. Эдгээр тэмдэглэгээ нь оюутны голч дүн буурах шалтгааныг тогтоох, оюутан голч дүнгээ хянах, дүнгээ ахиулах боломж олгох, бусад сургуулийн багц цагийг шилжүүлэн тооцох зэрэгт хэрэглэгдэнэ.
22	Сурлагын голч оноог хэрхэн	Бакалаврын сургалтын журмын 16.7-д зааснаар

	боддог вэ?	<p>Оюутны сурлагын чанарыг улирал бүрийн, мөн нийт суралцсан хугацааны голч оноо болон голч дүнгээр тодорхойлно. Голч оноо, голч дүнг бодохдоо багц цаг бүхий хичээл бүрээр оюутны авсан оноо/дүнг харгалзах багц цагаар нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг багц цагийн нийлбэрт хувааж (арифметикийн жинлэсэн дундаж), таслалаас хойш нэг орны нарийвчлалтай бодож гаргана.</p> $ГО = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot O_i}{\sum_{i=1}^n K_i} \quad ГД = \frac{\sum_{i=1}^n K_i \cdot Д_i}{\sum_{i=1}^n K_i}$ <p><math>n</math> - хичээлийн тоо  <math>K_i</math> - тухайн (<math>i</math>) дугаар хичээлийн багц цаг  <math>O_i (Д_i)</math> - тухайн (<math>i</math>) дугаар хичээлийн оноо (дүн)  <math>ГО (ГД)</math> - голч оноо (голч дүн)</p>
23	120 кредитээс илүү судалсан багц цаг хасагдах уу?	<p>Бакалаврын сургалтын журмын 20.2.5-д зааснаар Бакалаврын сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийг бүрэн судалж, 120-оос доошгүй багц цаг цуглуулсан оюутныг дээд боловсролын бакалаврын зэргээр төгсгөнө. Иймд илүү судалсан багц цагийг хасахгүй. Харин 120 кредитээс бага бол бакалаврын зэрэг олгохгүй.</p>
24	Эрүүл мэндийн даатгалаа яаж бөглүүлэх вэ?	<p>СНА-ны Оюутанд үйлчлэх төвийн мэргэжилтэн бүрэлдэхүүн сургуулиудаас оюутнуудын нэрсийг хүлээн авч баталгаажуулан Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн холбогдох мэргэжилтэнд өгдөг. Үүний дараа та эрүүл мэндийн даатгалын дэвтэрээ Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн нэгдэлд авч очин бөглүүлнэ.</p>